



МОНГОЛ УЛС
ГОВЬ-АЛТАЙ АЙМГИЙН
ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2024 оны 06 сарын 07 өдөр

Дугаар А/Н17

Есөнбулаг

Төр, захиргааны байгууллагуудын
ажлын цагийн хуваарьт зохицуулалт
хийх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 21 дүгээр зүйлийн 21.1.6 дахь заалт, 60.1.21 дэх заалт, 66 дугаар зүйлийн 66.1 дахь хэсэг, 77 дугаар зүйлийн 77.1 дэх хэсгийг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1.Албан хаагчдын ажлын бүтээмжийг нэмэгдүүлэх, цаг ашиглалтыг сайжруулах, амралт чөлөөт цагийг зохицуулах зорилгоор аймгийн хэмжээнд төр, захиргааны байгууллагуудын ажлын цагийг 2024 оны 06 дугаар сарын 10-ны өдрөөс эхлэн 08 дугаар сарын 31-ний өдрийг дуустал эхлэх цагийг 08:00 цагт, тарах цагийг 17:00 цагт, цайны цагийг 12:00 цагаас 13:00 цаг байхаар өөрчилсүгэй.

2.Энэхүү захирамжийг иргэд, олон нийтэд мэдээллэж, сурталчилан таниулах ажлыг Төрийн захиргааны удирдлагын хэлтэс (Я.Жаргалцэцэг)-т үүрэг болгосугай.

3.Захирамжийн хэрэгжилтийг хангаж ажиллахыг сумдын Засаг дарга, байгууллагын удирдлагуудад, хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аймгийн Засаг даргын Тамгын газар (Ш.Эрдэнэбат)-т тус тус даалгасугай.

ЗАСАГ ДАРГА



О.АМГАЛАНБААТАР

